



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 5/71

Хэрлэн сум

**Б.Энх-Уянгыг түр орлон  
гүйцэтгэгчээр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2, 43.3.4 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр “Журам батлах тухай” тогтоолоор баталсан ‘Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам’-ын 2.3 дах заалт, 2022 оны 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Жирэмсний болон амаржсаны амралттай байгаа Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Нутгийн захиргааны байгууллагын хяналт- шинжилгээ, үнэлгээ хариуцсан Ахлах мэргэжилтний албан тушаалд Батжаргалын Энх-Уянгыг түр орлон гүйцэтгэгчээр 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн томилсугай.

2.Б.Энх-Уянгын ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын

дарга: Ц.Ганчимэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Гишүүд: Б. Ундрахжаргал

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн  
мэргэжилтэн

Д.Энхтуяа

Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа

Нярав

3.Б.Энх-Уянгын цалинг ТЗ-7 зэрэглэлээр тогтоож, үндсэн цалинг 924456 (есөн зуун хорин дөрвөн мянга дөрвөн зуун тавин зургаа) төгрөгөөр, орон нутагт ажилласны нэмэгдлийн 40 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д үүрэг болгосугай.

4.Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоолын шийдвэр, байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Энх-Уянгад үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНТУЛГА

